

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН ГАЗРЫН АЛБАН ХААГЧДЫН НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙН
2025 ОНЫ ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

2026 оны 01 дүгээр сарын 11-ний өдөр

Орхон аймаг

№	Хөтөлбөрийн бодлого, зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах албан хаагч	Шаардагдах нөөц	Хүрсэн түвшин	Биелэлтийн хувь	ХШҮ-ний хувь
Арга хэмжээ 1. Албан хаагчдын амьдралын нөхцөлийг сайжруулах, тусламж дэмжлэг үзүүлэх хүрээнд								
1	Цалин хөлс, шагнал урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх	Монгол улсын Засгийн газрын шинэчилсэн тогтоол шийдвэрийг үндэслэн цалин хөлсийг тогтоож, олгох	Тухай бүр	СХДАГ-ын дарга Д.Сайзмаа, Ахлах мэргэжилтэн Л.Булганцэцэг Нягтлан бодогч Ж.Нямжаргал	Үйл ажиллагааны зардал	Оны эхэнд Аймгийн Засаг даргын 2025.01.10-ны өдрийн А/17 дугаар захирамжаар Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны бүтэц орон тоог баталсан. Газрын даргын 2025.01.10-ны өдрийн А/01 дугаар тушаалаар албан хаагчдын ажил, албан тушаалын жагсаалт, үндсэн цалингийн сүлжээ, бусад нэмэгдлийн хэмжээг шинэчлэн баталж 2025 онд 12 орон тоог батлан ажиллаж байна. ЗГ-ын 2025 оны 238 дугаар тогтоол, Аймгийн Засаг даргын 2025.02.11-ний өдрийн А/126 тоот захирамжаар Цалин хөлсний хэмжээ шинэчлэн тогтоох захирамжаар аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний төрийн байгууллагын хавсралтад нэр тусгагдсан удирдах ажилтнуудын цалин хөлсний хэмжээг шинэчлэн тогтоож 2025.01.01-ний өдрөөс мөрдөж цалин хөлсийг олгож ирсэн байна.	100%	100%
		Албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, үнэлгээ, ажилласан жил, ур чадварын байдлыг харгалзан зэрэг дэв нэмэгдүүлэх				Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоол, Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын хамтарсан 1996 оны 63/104 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн үйлчилгээний албаны түгээмэл мэргэжлийн албан хаагчдад ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам”-д заасны дагуу газрын даргын 2025 оны Б/05, Б/07, Б/10, Б/20, Б/21, Б/22 дугаар тушаалаар нягтлан бодогч, архив, бичиг хэргийн эрхлэгч нарт 25%-р тооцож сар бүр ажил гүйцэтгэх чадвар, ажлын арга барил, идэвх санаачилгыг дэмжин ур чадварын нэмэгдлийг олгосон байна.	100%	100%

		Албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг дүгнэж, үр дүнгийн урамшуулал олгох	Хагас бүтэн жилээр			Засгийн газрын 2023 оны 301, 442 дугаар тогтоолд заасны дагуу газрын даргын 2025 оны Б/12, Б/13, Б/25, Б/26 дугаар тушаалаар ТЗ, ТҮ, ТҮМ албан хаагчид үндсэн цалингийн 50%-100%-р тооцож хагас жил, бүтэн жилээр ажил гүйцэтгэх чадвар, ажлын арга барил, идэвх санаачилгыг дэмжин үр дүнгийн урамшуулалын нэмэгдлийг олгосон байна.	100%	100%
		Албан хаагчдад хоол, унааны зардлыг сар бүр олгох	Сар бүр			Байгууллагын даргын 2022.03.04-ний өдрийн А/09 дүгээр тушаалаар баталсан Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу хоолны зардалд 5000 төгрөгөөр олгож байсныг 2023.10.27-ны өдрийн А/27 дугаар тушаалаар Төрийн албаны ёс зүйн тухай хууль шинээр батлагдсан, албанд нэгдсэн менежментийн тогтолцоо хэрэгжиж байгаатай холбогдуулан Хөдөлмөрийн дотоод журамд нэмэлт өөрчлөлтийг 7.12-д заасан заалтаар оруулан хоол унааны мөнгийг 8500 төгрөг болгон олгохоор шийдвэрлэж, одоог хүртэл олгож байна. 2025.01 сараас хоол унааны мөнгийг 13.0 мянган төгрөг олгож байсан бөгөөд 2025.10.07-ны А/44 тушаалаар баталсан хөдөлмөрийн дотоод журманд 15,0 төгрөг болгон нэмэгдүүлэн мөрдөж ажиллаж байна.	100%	100%
		Албан хаагчдын ажлын үр дүнг харгалзан шагнал урамшуулалд тодорхойлох	Тухай бүр			Байгууллагадаа тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллаж байгаа Дотоод аудитор-санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч Б.Баасансүрэн орон сууцны нөхцөл сайжруулах дэмжлэгт хамрагдаж 7 сая төгрөг авсан. Мөн хамт олноо манлайлан ажилласан Б.Баасансүрэн, П.Азхишиг, П.Даваажаргал нарыг салбарын тэргүүнд шагнуулахаар Сангийн яамнд 11 дүгээр сард хүсэлт илгээсэнээс П.Азхишигт Санхүү банкны тэргүүний ажилтан цол тэмдэгээр шагнуулсан.	100%	100%
		Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу албан хаагчдад	Жилдээ			Хөдөлмөрийн дотоод журмын 9.3.22-д заасан заалтын дагуу гэр хороололд амьдардаг 1 албан хаагчид түлээ нүүрсний хөнгөлөлт болох 350,0 мянган төгрөгийн дэмжлэг үзүүлсэн байна. Хүүхэд хамгааллын зардлаас 11 албан хаагчийн 11 хүүхдэд тус бүр 100.0 төгрөгийн сургалтын төлбөрийн	100%	100%

		нэг удаагийн тэтгэмж олгож дэмжлэг үзүүлэх				дэмжлэг, мөн улсдаа төдийгүй тив дэлхийд амжилт гаргасан 1 сурагчид 300.0 төгрөгийн дэмжлэгийг тус тус үзүүлсэн.		
Арга хэмжээ 2. Хүний нөөцийн чадавхийг бэхжүүлж, үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах хүрээнд								
2	Албан хаагчдын ажлын байрны хэвийн таатай нөхцлийг бүрдүүлсэн байдал	Ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай тоног төхөөрөмж, бичиг хэргийн хэрэгсэлээр хангах	Тухай бүр	Нягтлан бодогч Ж.Нямжаргал	Үйл ажиллагааны зардал	Байгууллагын бичиг хэргийн зардал сард 400.0 мянган төсөвлөгдөж 4-р улирлын байдлаар 4,400.0 мянган төгрөгийг бичиг хэргийн зардалд зарцуулсан байна.	100%	100%
		Ажлын байрны орчин нөхцөлийг сайжруулах (өрөө тасалгаа тохижилт, гэрэлтүүлэг, цахилгаан хангамж гэх мэт)				Ажлын байрны орчин нөхцөлийг сайжруулах чиглэлээр нийт 33,075.0 мянган төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдан авч албан хаагчдын өрөө тасалгааны тохижилтыг хийсэн байна. Үүнд: 5 дэлгэц, принтер 1, ус шүүгч аппарат 1, зөөврийн компьютер 1, нүүр уншигч төхөөрөмж 1, ширээ-туслахтай 5, шүүгээ 1, сандал 16, процессор 3, гурван үйлдэлт хэвлэгч 2-г тус тус худалдан авч ажлын байрны орчин нөхцөлийг дээшлүүлсэн байна. Мөн албан тасалгааны хана шал таазанд засвар хийх, гэрэл суултуур, хаалга цоож зэргийг сольсон урсгал засварт 7,693.2 мянган төгрөгийг зарцуулан өнгө үзэмжийг дээшлүүлсэн.	100%	100%
		Албан ажлын хэрэгцээ, ажил үүргээ гүйцэтгэхэд албаны унаагаар хангах				Байгууллагын шатахууны зардал сард 350.0 мянган төгрөг төсөвлөгдөж эхний хагас жилийн байдлаар 3,760.0 мянган төгрөгийн түлш шатах тослох материалыг анхан шатны баримтаар зарцуулсан байна.	100%	100%
		Сургалтын төлөвлөгөөний дагуу албан хаагчдыг мэргэшүүлэх, чадавхижуулах, гадаад, дотоодод давтан сургах				Байгууллагын хэмжээнд “Соёлын хөтөлбөр” 2 дахь жилдээ хэрэгжиж байгаатай холбоотой зөв ойлголт, хандлагыг төлөвшүүлэх, байгууллагын соёлоо үнэлэх, цаашид эерэг хандлагыг түгээх чиглэлээр албан хаагчдыг холбогдох бусад байгууллага болон дотооддоо зохион байгуулагдаж буй сургалтуудад байгууллагын сургалтын	100%	100%

						төлөвлөгөөний дагуу тухай бүр хамруулан ажиллаж байна. Олон Улсын Стандартын академиас зохион байгуулсан ISO 9001:2015 Чанарын менежментийн тогтолцооны Олон улсын стандарт, ISO 37001:2024 Авлигын эсрэг менежментийн тогтолцооны Олон улсын стандарт, ISO 31000:2020 Эрсдэлийн менежментийн тогтолцооны Олон улсын стандартуудын сургалтад албан хаагчдын ур чадвар мэдлэгийг бататгах зорилгоор 2 өдрийн сургалтад бүх албан хаагчдаа хамруулан ажиллалаа. Дотоод аудитор байцаагч нарын мэргэжлийн ур чадвар дээшлүүлэх, туршлага, хууль эрхзүйн мэдээллийг цаг тухай бүр нь солилцож байх зорилгоор Монголын үндэсний дотоод аудитуудын холбооны гишүүнээр элсэн холбогдох сургалтад албан хаагчдаа хамруулан ажиллаж байна. Ворлд консалтинг ХХК-тай хамтран ажиллах гэрээний үндсэн дээр Нэгдсэн менежментийн тогтолцооны стандартуудад GAP буюу зөвлөх үйлчилгээ, зөрүүгийн шинжилгээ хийлгэн зөвлөгөө мэдээллийг авч ажиллалаа. “Coaching and feedback” сургалтад хамрагдлаа.		
		Сул орон тоог нөхөх ажлыг зохион байгуулж, албан хаагчдын ажлын ачааллыг тэнцвэржүүлэх				Аймгийн засаг даргын А/17 тоот захирамжийн дагуу батлагдсан орон тоонд заасан нярвын орон тоон дээр М.Алтанзулыг 2025.01.27-ны өдрийн Б/03 тоот тушаалаар томилж цалин хөлсийг тогтоож хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж байна. Мөн газрын даргын 2025.05.19-ний өдрийн Б/09 дүгээр тушаалаар М.Алтанзулыг Дотоод аудитораар томилон ажиллуулж сул орон тоог нөхөж ажилласан байна.	100%	100%
Арга хэмжээ 3. Албан хаагчдын ажлын байрны нөхцөл, хангамжийг сайжруулах, үр дүнтэй ажиллах нөхцөл бололцоог хангах хүрээнд								
3	Албан хаагчдын эрүүл мэндийг	Эрүүл аж төрөх, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан	Тухай бүр	Нягтлан бодогч Ж.Нямжаргал	Үйл ажиллагаа ны зардал	Орхон аймгийн эрүүл мэндийн газраас 2025.04.03-ны өдөр "Шүд эрүүл бол бие эрүүл" 2025.04.14-ний өдөр Эрүүл мэнд анхны тусламж сургалтуудыг авч ажилласан.	100%	100%

	хамгаалах, урьдчилан сэргийлэх	сэргийлэх зорилгоор нарийн мэргэжлийн эмч нарын зөвлөгөө авах, лекц уншуулах						
		Албан хаагчдыг ажиллах нөхцөл, шаардлагатай техник хэрэгслээр ханган ажиллах				Ажлын байрны орчин нөхцөлийг сайжруулах чиглэлээр нийт 33,075.0 мянган төгрөгийн үнэ бүхий тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдан авч албан хаагчдын өрөө тасалгааны тохижилтыг хийсэн байна. Үүнд: 5 дэлгэц, принтер 1, ус шүүгч аппарат 1, зөөврийн компьютер 1, нүүр уншигч төхөөрөмж 1, ширээ- туслахтай 5, шүүгээ 1, сандал 16, процессор 3, гурван үйлдэлт хэвлэгч 2-г тус тус худалдан авч ажлын байрны орчин нөхцөлийг дээшлүүлсэн байна. Мөн албан тасалгааны хана шал таазанд засвар хийх, гэрэл суултуур, хаалга цоож зэргийг сольсон урсгал засварт 7,693.2 мянган төгрөгийг зарцуулан өнгө үзэмжийг дээшлүүлсэн.	100%	100%
		Хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх, ажлын чадварыг нэмэгдүүлэх зорилгоор ажлын байрны дасгал хөдөлгөөнийг тогтсон хугацаанд хийлгэж хэвшүүлэх				Ажлын байрны дасгалыг өдөр бүр тогтмол 1-2 удаа хийж хэвшсэн. Албан хаагчид тус бүрдээ өөрсдийн мэдэх ажлын байрны дасгал хөдөлгөөний хийж хэвшлээ. Мөн албан хаагчид өөрсдийн сонирхсон спорт клубт хичээллэж байна. Албан хаагчид долоо хонгийн пүрэв гариг бүр зааланд 20 цагаас 2 цаг заал авч хөдөлгөөний дутагдлаас сэргийлэх зорилгоор арга хэмжээ авч ажилласан байна.	100%	100%
		Албан хаагчдыг нарийн мэргэжлийн эмчийн үзлэгт хамруулах				Албан хаагчдыг Таван богд Нура ХХК-ны эрт илрүүлгийн багц шинжилгээнд бүрэн хамруулж ажиллалаа. Үүнд 10780.0 төгрөгийг зарцуулсан байна. Шинжилгээний хариунд үндэслэн албан хаагчдыг нарийвчилсан шинжилгээнд хамрагдах	100%	100%

						боломжоор ханган шаардлагатай үед цалинтай чөлөө олгон ажиллаж байна.		
		Ахмад настны тухай хуулийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд байгууллагын өндөр насны тэтгэвэрт гарсан ахмадуудыг хүлээн авах, хүндэтгэл үзүүлэх				Ахмад настны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д зааснаар Монголын уламжлалт Цагаан сарын баярыг тохиолдуулан 4 ахмад настанд нийт 800,0 мянган төгрөгийн тэтгэмж олголоо.	100%	100%
Биелэлтийн дундаж хувь							100%	100%

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, ДОТООД АУДИТЫН ГАЗАР